

“ДОРНОД АВТО ЗАМ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 20 өдөр

№ 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал хуралдуулах тухай

“Дорнод авто зам” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, олонхийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Дорнод авто зам” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 30-ний өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Бармашын 213 тоотод зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - a. Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
 - b. Компанийн аудитын хорооны тайлан, дүгнэлтийг батлах
 - c. 2023 оны ажлын төлөвлөгөөг батлах
 - d. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын 2023 оны зардлын төсвийг батлах
 - e. Ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2023 оны 04 дугаар сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2020 оны 03 дугаар сарын 24-ны өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээллэх. Энэ мэдээллийг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 4 сарын 09-ны өдөр дахин зар гаргахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримттай 2023 оны 03 сарын 28-ний өдрөөс хойш 08⁰⁰-

17⁰⁰ цагийн хооронд “БиДиСЕК” ХК-ийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харъяалагдах брокер, дилерийн компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5-с доошгүй хоногийн өмнө байхаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ж.Энхболд, Хурал зохион байгуулах комиссын даргаар А.Мягмаржав, Тооллогын комиссын даргаар А.Мягмаржав, гишүүнээр Т.Энхзул тус тус томилсугай.


Төлөөлөн Удирдах

Зөвлөлийн дарга:



Ж.ЭНХБОЛД


Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны
3 дугаар сарын 20-ний өдрийн 02
дугаар тогтоолын "Хавсралт-1"



**“ДОРНОД АВТО ЗАМ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

1	Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг)	15:00-15:10
2	Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг)	5 минут
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	10 минут
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах	40 минут
5	Хурлын завсарлага	10 минут
6	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
7	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
8	Хурлыг хаах (хурлын дарга)	5 минут

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 20-ний өдрийн 02 дугаар тогтоолын "Хавсралт-2"



**“ДОРНОД АВТО ЗАМ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайлан, дүгнэлтийг батлах
3. 2023 оны ажлын төлөвлөгөөг батлах
4. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын 2023 оны зардлын төсвийг батлах
5. Ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 20-ний өдрийн 02 дугаар тогтоолын "Хавсралт-3"



**“ДОРНОД АВТО ЗАМ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛАВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар:

Регистерийн дугаар :

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн / Брокер диллерийн компани /

Брокерийн овог нэр

“Дорнод авто зам”ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4 дүгээр сарын 30-ний өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Бармашын 213 тоотод хуралдах болно.

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах			
2.	Компанийн аудитын хорооны тайлан, дүгнэлтийг батлах			
3.	ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгох			
4.	ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын 2023 оны зардлын төсвийг батлах			
5.	Ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах			
6.				

Брокер Гарын үсэг

/ тэмдэг /

Хувьцаа эзэмшигч Гарын үсэг

2023 оны 3 сар 20 өдөр